



ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ
нь ҮНШИХ, БИЧИХ, ТОО БОДОЖ
сурахын нэгэн адил амни чухал

HUMAN RIGHTS EDUCATION
as basic as
READING, WRITING AND
ARITHMETIC

2007 оны 2 дугаар сар

Тусгай дугаар

Хүний Эрхийн Боловсрол гэж юу вэ?

• Хүний Эрхийн Боловсрол нь бие хүн, бүлэг, нийгмийн бүлэглэлд олон улсын хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн зарчимд нийцсэн мэдлэг, чадвар болон хандлагыг бий болгох замаар тэднийг хүчтэй болгоход чиглэгдсэн үйл ажиллагаа юм.

• Түүний зорилго нь бүх нийтийн хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах, хүндлэхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хүний эрхийн соёлыг бүрэлдүүлэх явдал юм.

Хүний Эрхийн Боловсрол олгохдоо:

• Сургалтын арга зүй нь хүний эрхийн зарчмуудад нийцсэн байна. Хөтөлбөрийн загвар хэрэгжүүлэх арга зам, мөн үйл ажиллагаанууд нь эдгээр зарчимд нийцсэн тулгуурласан байх

• Сургалтын орчин нь өөрөө хүний эрхийг хүндэтгэсэн, хувь хүн өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэлэлцэж байгаа асуудлаар хэлэлцүүлэг болон мэтгэлцээнд чөлөөтэй оролцох тийм соёлын орчинг бүрдүүлсэн байх

• Сургалтын хөтөлбөр ба үйл ажиллагаа нь бүлгийн тусгайлсан хэрэгцээг хангахад чиглэгдсэн, зорилго, зорилтыг нь нарийн тодорхойлсон байх

• Сургалтын хөтөлбөр нь хүмүүст мэдлэг олгоод зогсохгүй өөрсдийнхөө болон бусдын нэрийн өмнөөс аливаа үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог болоход нь шаардлагатай чадварыг зааж сургахад чиглэгдэнэ.

Монголын Эмнести Интернэшнл НҮБ-ын ХЭБ-ийн Дэлхийн хөтөлбөрийг дэмжиж ажиллалаа.

Хүний эрх, эрх чөлөөг эн тэргүүнд тавьж, хөгжлийн шинэ бодлого ч хүн рүүгээ илүү анхаарлаа хандуулж байгаа өнөө үед хүн бүр хувийн эрх, эрх чөлөө ба аюулгүй байдлаа хангах, бие бялдар, оюун ухааны хувьд бололцоотой хамгийн дээд түвшинд хүрч хөгжих эрхтэй юм. Тэгвэл хүнийг хөгжилд хүргэж амьдралын чанарыг сайжруулахад гарцаагүй шаардлагатай хэрэглэгдэхүүн нь боловсрол юм.

Иймээс Хүний Эрхийн Боловсрол нь Чанартай Боловсролын нэг салшгүй хэсэг бөгөөд

Дакарын Хурал болон Мянганы Тунхагалд: “Бүх нийтийн чанартай боловсролд хүрэх, ингэснээр бие хүнийг хөгжилд хүргэх боловсролыг эзэмшүүлэх ба улмаар ядуурлыг бууруулан, хүмүүсийн амьдрах чадварыг дээшлүүлж чадсанаар тогтвортой хөгжилд хүрнэ” гэж тунхагласан байдаг.

2004 оны 12 сарын 10-нд НҮБ-аас батлан гаргасан ХЭБ-ын Дэлхийн Хөтөлбөрийн дагуу 2005-2008 он хүртэлх эхний 3 жилд Засгийн газрууд бага ба дунд боловсролын хүрээнд ХЭБ-ын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхийг зорилтоо болгосон бөгөөд Эмнести Интернэшнл байгууллага ч энэ зорилтыг дэмжин үйл ажиллагааныхаа нэг гол чиглэл болгож ирлээ.


Энэ зорилтын хүрээнд Монголын Эмнести Интернэшнл байгууллага нь “Бага дунд боловсролын байгууллагын багш нарт зориулсан Хүний Эрхийн Боловсрол” төслийг 2006 оны 5 сарын 1-нээс 2007 оны 2 сарын 1-ний хооронд Монгол – Австралийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны Хөтөлбөр болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр амжилттай хэрэгжүүлээ.

Энэхүү төслийн зорилго нь Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын хүний эрхийн талаархи мэдлэг боловсрол болон эрхэд суурилсан боловсролын талаархи мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх замаар хүүхдийн эрхэд суурилсан чанартай боловсролыг дэмжих, хүний эрхийг бүхий л боловсролын тогтолцоогоор, ЕБС-ийн хичээлүүдээр нэгтгэх замаар суралцагчдад суралцах таатай орчинг бүрдүүлэн чанартай боловсрол эзэмших нөхцлийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулахад оршиж байлаа.

Төслийн хүрээнд Эмнести Интернэшнлийн Английн секцээс гаргасан “Хүний Эрх Сургалтын Хөтөлбөрт” цувралын “Математик” ба “Түүх” номыг англи хэлнээс орчуулан тус бүр 1000ш, ХЭБ-ын 2 ширхэг зурагт плакатыг тус бүр 1000ш, ХЭТТ-ын хялбаршуулсан плакат 500ш-ийг сургалтын гарын авлага болгон хэвлүүллээ.



Төслийн баг. Улаанбаатар.
2006 оны 6 сар



“Хүний эрх - Сургалтын хөтөлбөрт” сургалт

Энэхүү төслийн хүрээнд “Хүний эрх-Сургалтын хөтөлбөрт” сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Говьсүмбэр, Завхан аймаг, Дорнод аймаг, Багануур дүүргийн нийт 763 багш, сургуулийн удирдлага, Боловсрол Соёлын Газрын арга зүйчид, Хүүхэд хамгаалал Төвийн ажилтнууд хамрагдлаа. Сургалтанд оролцогчдын бүтцийг авч үзвэл: Сургалтанд оролцсон нийт 763 оролцогчдоос орон нутгийн БСГ-ын арга зүйч 18, сургуулийн захирал 11, сургалтын менежер 120, нийгмийн ажилтан 89, ЕБС-ийн багш 509, цэцэрлэгийн арга зүйч 8, цэцэрлэгийн эрхлэгч 3, Хүүхэд Хамгаалал Төвийн ажилтан 5 байлаа.

Сургалтын явцад багш нар Хүний эрхийн Түгээмэл тунхаглал, Монгол Улсын Үндсэн Хууль болон бусад эрх зүйн баримт бичгүүдтэй ажиллаж, ЭНСЭ, Цэвэр усаар хангагдах эрх, Хүүхдийн эрхийн Конвенц зэрэг олон улсын баримт бичгүүдтэй танилцан бүлгээр ажиллалаа.



Завхан аймагт хийсэн эхний сургалтын сүмдүүдэн сургуулийн захирал, сургалтын менежерүүд хамрагдлаа.

Энэ сургалтын нэг үндсэн санаа нь ЕБС-ийн хичээл бүрээр хүний эрхийг нэгтгэж заах тухай ойлголтыг өгөх явдал байв. Энэ чиглэлийн дадлага, бүлгийн ажил нь байгаль, нийгмийн болон хүмүүнлэгийн хичээлдүүдийн нэгдмэл байдлыг хангахад чиглэгдсэн ч хүн ирээдүйдээ байгаль, нийгмийн аюулгүй орчинд амьдрах арга ухаан, иргэншлийн өндөр соёлыг эзэмшсэн байхын чухлыг шавь нартаа мэдрүүлэхэд багш нарт туслах явдал байлаа.

Нийслэлийн Боловсролын Газартай хамтран “Хүний эрх –Сургалтын хөтөлбөрт” сургалтыг 2006 оны 9 сараас эхлэн зохион байгууллаа. Үг сургалтанд нийслэлийн ЕБС-ийн сургалтын менежер, нийгмийн ажилтан, багш нийт 372 хүн хамрагдлаа. Нийслэлийн Боловсролын Газрын ажилтнууд сургалтанд манай сургалтын үзэл санааг цаашид илүү олон багшид хүргэхэд чухал үүрэг бүхий нийслэлийн ЕБС-иудын сургалтын менежерүүд, нийгмийн ажилтнуудаа түлхүү хамруулан дэмжиж ажиллалаа.

Сургалтанд оролцогчдоод Сертификат олгосон бөгөөд сургалтыг багш нарын мэргэжлийн заах арга зүйг шинэ агуулгаар баяжуулж, хичээлийг амьд хичээл болгох, хүүхдэд эрхийн мэдрэмжийг хөгжүүлж, чанартай боловсрол эзэмшүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр болж байна гэж үзэж аймаг, нийслэлийн боловсролын газраас сургалтанд оролцсон бүх багш нарт 1 кредит цаг олгож дэмжиж ажиллалаа. Энэ нь багшид багшлах ажлын ур чадвараа дээшлүүлж, мэргэжлийн зэргээ ахиулахад нь багшид бас нэг чухал хувь нэмэр болсноороо төслийн нэг гол ач холбогдол боллоо.

Дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт иргэншлийн хичээлийн эзлэх байр суурь өсөн нэмэгдэж байгаа энэ үед энэхүү төслийн хүрээнд хийгдэж байгаа сургалтууд болон сургалтын гарын авлага материалууд нь ЕБС-ийн багш нарт чухал хувь нэмэр боллоо гэж сургалтанд оролцогчид болон орон нутгийн Боловсрол, Соёлын Газрын ажилтнууд өндөрөөр үнэллээ.



Нийслэлийн Боловсролын Газрын дарга Д.Энхбаяр, мэргэжилтэн Ц.Оюун, ХЭБ-ын зохицуулагч С.Ганчимэг нар ажлын үүлзлэлийн үеэр. Улаанбаатар хот.



Нийслэлийн Боловсролын Газрын дарга Д.Энхбаяр сургалтыг нээж үг хэлэв. Улаанбаатар хот.

Сургагч багшийн сургалт

Төслийн хүрээнд сургагч багшийн 3 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Байгууллагын гишүүдийн чадавхийг дээшлүүлэхэд уг сургалт нь чухал түлхэц боллоо.

Бэлтгэгдсэн сургагч багш нараас Багш нарын бүлгийн Х.Балдан, Д.Даариймаа, Багануурын бүлгийн Б.Цэцгээ, сэтгэл зүйч багш Д.Оюунномин, хөгжлийн зохицуулагч А.Отгончимэг, гүйцэтгэх захирал Б.Алтантуяа, ХЭБ-ын зохицуулагч С.Ганчимэг нар сургагч багшаар ажиллав.



2006 оны 8 сар.

Мөн Нийслэлийн Боловсролын Газрын мэргэжилтэн Г.Шүрэнцэцэг, Б.Цэндсүрэн, Ч.Даваадорж, С.Жагдал нар үнэтэй зөвлөгөө өгч түүх-нийгмийн ухааны арга

зүйч, докторант Г.Шүрэнцэцэг сургагч багшаар ажиллалаа.

Орон нутагт өөрийн байгууллагыг сурталчлан таниулах, гишүүд дэмжигчдийн эгнээг өргөтгөхөд уг төсөл зохих хувь нэмрээ оруулсан юм. Сургалтанд оролцогчдоос манай байгууллагын гишүүн болохоор Дархан хотоос 5, Улаанбаатар хотоос 6, Эрдэнэт хотоос 3, Дорнод аймгаас 2, Багануур дүүргээс 3 багш санал хүсэлтээ ирүүллээ.

Сургалтанд оролцогчдын дунд явуулсан хүний эрхийн хөгжөөнт тоглоомын азтанг шалгаруулж байгууллагын лого бүхий футволкоор урамшуулж байсан нь сургалтыг улам бүр сонирхолтой болгосон юм.



Д.Оюунномин багшийн харилцааны тухай хичээл нь сургалтанд оролцогчдын сонирхол татсан нэг хэсэг байсан юм.



Сургагч багш Х.Балдан. Аж үйлдвэржилтийн үе дэх хүүхдийн хөдөлмөр сэдвээр бүлгээр ажиллуулж байгаа нь. Говь-Сүмбэр аймаг



Сургагч багш Д.Даариймаа. Түүхийн хичээлээр хүний эрхийг заах нь сэдвээр сургалт явуулж байгаа нь.

Хүний эрхийг хичээл бүрээр нэгтгэж заах нь.

Сургалтуудыг оролцооны аргаар зохион байгуулсан бөгөөд дунд сургуулийн хичээлүүдээр хүний эрхийн тухай ойлголтыг хэрхэн нэгтгэж зааж болох талаар булангийн аргаар ажилласны эцэст багш нар бүлгээр ажиллаж өөр өөрсдийн мэргэжил дээр нийт 94 сэдвээр нэгж хичээлийн төлөвлөгөөг хамтран боловсруулж бүлгээр ажиллан олон сайхан санааг дэвшүүлэн гаргаж түүнийгээ хэлэлцүүлсэн нь сургалтын нэг чухал үр дүн болсон юм.

Үүнийг хичээл бүрээр авч үзвэл:

| Хичээлийн нэр | Сэдвийн тоо |
|------------------------------------|-------------|
| Бага ангийн хичээлээр | 11 |
| Дуу хөгжмийн хичээлээр | 5 |
| Биеийн тамирын хичээлээр | 2 |
| Дүрслэх урлагийн хичээлээр | 3 |
| Математикийн хичээлээр | 16 |
| Монгол хэл-Уран зохиолын хичээлээр | 15 |
| Түүх-Нийгмийн ухааны хичээлээр | 20 |
| Байгалийн ухааны хичээлээр | 19 |
| Англи хэлний хичээлээр | 2 |
| Экологийн хичээлээр | 1 |
| Нийт | 94 |

Багш нар шинжлэх ухааны суурь ойлголтуудыг хүний эрхийн хэрэгжилтийн үзүүлэлтүүд, бодит байдалтай холбон заах

боломжтой төдийгүй энэ нь амьдралд ойр, суралцагчдын эрэлт хэрэгцээг хангасан бүтээлч арга зүй болдгийг санал нэгтгэж хүлээн зөвшөөрч дэмжиж байлаа. Багш энэ арга зүйг эзэмшиж хэрэгжүүлсэнээр суралцагчид нь түүх, нийгэм, байгалийн ухаан, математикийн хичээлээр өөрийн орны инфляцийн түвшинг тодорхойлж, улс орныхоо хөгжлийн нэгдсэн үзүүлэлтийг тооцон ядуурлын түвшин, ажилгүйдлийн коэффициентийг бодож энэ нь хүний эрх, үүргийн заалтуудтай хэрхэн холбогдож байгааг дүгнэн эрх үүргийнхээ хэрэгжилтэнд хяналт тавьж сурах чадваруудыг бодитоор эзэмших боломжтой болгоход зохих үр дүнгээ өгөх юм байна гэдэгт санал нэгдэж байсан юм.

Хүний эрх түүхийн хичээлээр:



Энэхүү ном нь сургалтын хөтөлбөр дэх хүний эрх хэмээх шинэ цувралуудын нэг бөгөөд багш сурган хүмүүжүүлэгчид, хүний эрхийн боловсрол болон энэ чиглэлээр ажилладаг салбарын хүмүүст зориулсан юм. Хүний эрхийн асуудлыг сургалтын хөтөлбөрт оруулж, түүхийн хичээлээр заахаар тусгасан энэ ном нь дунд сургуулийн түүхийн хичээлээр хүний эрх болоод иргэний эрхийн талаар заах, энэ чиглэлээр судалгаа хийдэг хүмүүст чухал гарын авлага болно. Энэхүү номонд Фашистууд Еврейчүүдийг үй олноор нь устгасан гэмт хэрэг, хүүхдийн хөдөлмөр, эмэгтэйчүүдийн сонгуулийн эрх зэрэг өргөн хүрээний чухал сэдвүүдийн дагуу ангид хийх үйл ажиллагаа, дасгалуудыг багтаасан юм.



Дорнод аймгийн түүх нийгмийн ухааны багш нар аймгийн БСГ-ын арга зүйч Наранчимэгийн хамт. 2006 оны 11 сар.



«Хөрөнгө хураалт» сэдвээр ажиллаж байгаа нь. Орхон аймаг. 2006 оны 9 сар.

Түүх бол хүний эрхийн хөгжил хувьслыг заах үндэс тулгуур бөгөөд үе үеийнхний хүний эрхийн төлөөх тэмцэл, хөдөлгөөн болон хүний эрхийн тунхаглалын зарчим, хэм хэмжээ, конвенц протоколуудыг түүхийн хичээлээр заах бүрэн боломжтойг түүхийн багш нар болон арга зүйчид бүлгээр ажиллаж харууллаа. Хүний эрх түүний зөрчигдөх явдалтай холбоотой үйл явдлуудыг орчин үеийн дэлхийн түүх, дэлхийн I, II дайны түүхээр дамжуулан судлах өргөн боломжтой юм. Мөн аж үйлдвэрийн хувьсгал нийгмийн бусад хөдөлгөөнүүдийн түүхийг эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдтэй холбож тоймлон үзэж болно. “Дэлхийн II дайн”, “Манжийн дарлал дахь Монгол орон” “Хөрөнгө хураалт”, “Улс төрийн хэлмэгдүүлэлт”, “1990 оны ардчилсан хувьсгал” зэрэг сэдвүүдээр түүх, нийгмийн ухааны хичээлийг хүний эрхтэй нэгтгэж заах маш өргөн боломж байгааг тэд бүлгээр ажиллан гаргаж ирлээ.

Хүний эрх математикийн хичээлээр:



Хүний Эрх Сургалтын Хөтөлбөрт: цувралын “Математик” ном нь Иргэншлийн боловсролын агуулга дахь хүний эрхийн бүхий л асуудлуудыг дунд сургуулийн математикийн хичээлийн агуулгад тусгаснаараа чухал ач холбогдолтой болсныг сургалтанд оролцогчид үнэлж байлаа.

Сургалтанд оролцогчдоос өгсөн үнэлгээний хуудаст сургалтын гарын авлага материал хир түвшинд хангагдав? гэсэн асуултад сургалтанд оролцогчдын 99.1% нь маш сайн гэж хариулсан байлаа.

Хүний эрхийн асуудлыг математикийн хичээлтэй хамааруулан ойлгох талаар учир дутагдалтай байдаг. Тэгвэл Хүний Эрх Сургалтын Хөтөлбөрт: цувралын “Математик” ном нь хүний эрхийг математикийн хичээлд нэгтгэж өгснөөрөө энэ ойлголтыг таягдан хаяхад чухал ач холбогдолтой алхам боллоо.

Хүний эрхийн нөхцөл байдлыг тодорхойлоход математик үргэлж хэрэглэгдэж иржээ. Математик нь бидэнд эх дэлхийгээ илүү сайн ойлгоход тусалж ирсэн ба математикгүйгээр бид дэлхий дээр болж байгаа үйл явдлын чиг хандлагыг судалж шинжилж чадахгүй.



Математикийн багш нарын баг. Дархан-уул аймаг. 2006 оны 10 сар



Математикийн багш нарын баг. Говьсүмбэр аймаг. 2006 оны 11 сар

Хүний эрхийг хичээл бүрээр нэгтгэж заах нь.

Хүний эрх уран зохиолын хичээлээр:

Бүх үеийнхний хүний эрхийн тухай асуудлууд үндэсний болоод гадаадын уран зохиолд тусгагдсан байдаг ба өөрийн үндэсний уран зохиол нь хүний эрхийн зөрчлийг ойлгох, тэдгээрийн талаар санал сэтгэгдлээ солиход хамгийн хялбар арга зам байдгийг хэл, уран зохиолын багш нарын баг "Хоньчин Найдан", "Гологдсон хүүхэн", "Цагаан сар ба хар хулимс" "Шүхэрч Буниа", "Манай сургуулийнхан" "Тунгалаг тамир" зэрэг тууж, роман, өгүүллүүдээр гаргаж үзүүлж байлаа.

Уран зохиолын хичээлээр хүний эрхийг заах нь:

- Бүтээлчдийн намтар түүхээр
- Тодорхой уран бүтээл дээр
- Дүр дүрслэл дээр ч



Сургагч багш А.Отгончимэг. Алжаал тайлах мөчид



23-р сургуулийн монгол хэл-уран зохиолын багш С.Оюунаа эхний эгнээний зүүн гар талд.



Монгол хэл, уран зохиолын багш нарын баг. Дархан-уул аймаг. 2006 оны 10 сар.

Хүний эрх хөгжим, урлагийн хичээлээр:

Хөгжим урлагийн бүх төрлийн хичээл нь хүний эрхийн боловсролын нэн тохиромжтой хичээл болохыг энэ мэргэжлийн багш нар бүлгээрээ ажиллан гаргаж үзүүллээ. Тухалбал: Нийгмийн

тодорхой үзэгдэл, хөдөлгөөний гэрч болдог ардын дуу, хөгжмийг хүний эрхийн төлөө тэмцлийн түүхийн тухай ойлголтыг дээшлүүлэхэд ашиглаж болохыг монгол ардын дуу "Сэндэр охин", "Борын тухай дуу" зэрэг сэдвээр хөгжмийн хичээлээр зааж болох тухай багууд ажиллалаа. Нийслэлийн

4-р сургуулийн хөгжмийн багш Олоннэмэх ахлагчтай баг хөгжмийн хичээлээр хүний эрхийг хэрхэн нэгтгэж зааж болохыг болон хичээл хоорондын интеграцыг хэрхэн хийж болохыг "Цаасан шувуу" дууны утга санаагаар гаргаж ирсэн нь үнэхээр үлгэр жишээ сайхан ажил боллоо.



Хөгжмийн хичээлийг «Цаасан шувуу» дугаар хүний эрхтэй холбож заах нь сэдвээр ажилласан Олоннэмэх ахлагчтай баг. Улаанбаатар хот



Монгол ардын дуу «Сэндэр охин» дугуу сонгон хөгжмийн хичээлийг хүний эрхтэй нэгтгэж заах нь сэдвээр ажиллаж байгаа нь. Орхон аймаг. 2006 оны 9 сар.



Репиний амьдрал уран бүтээлийг судлах явцдаа хүний эрхийг ойлгуулах нь. Говьсүмбэр аймгийн дүрслэх урлагийн багш нарын баг.

Хүний эрх бага ангийн хичээлүүдээр:

Бага ангид сурагчдад хүний нэр төр, онцлог байдлыг хүндэтгэх хандлагыг багаас нь хөгжүүлэх нь хамгийн чухал гээд энэ хандлагыг төлөвшүүлэхийн тулд Бага ангийн багш нарын багууд "Эвтэй дөрвөн амьтан", "Долоон бор оготно", "Хөхөө", "Сандарсан тотийн худал хэлсэн нь" "Ухаант оготно" үлгэр зэрэг сэдвийг сонгон хүний эрхийн ойлголттой нэгтгэн заах хичээлийн төлөвлөлт хийж байсан нь хүн бүрийн сонирхлыг татаж байлаа.



Бага боловсролд хүний эрхийг нэгтгэх нь. 2006 оны 10 сар. Дархан-уул аймаг.



2006 оны 10 сар. Багануур.

Хүний эрхийг хичээл бүрээр нэгтгэж заах нь.

Хүний эрх байгалийн ухааны хичээлүүдээр:

Хүний эрх хүний хэрэгцээг тодорхойлдог бөгөөд хүний эрх мөн хүний үүрэг хариуцлагаас хамааралтай байдаг. Тодруулбал: Байгаль хүрээлэн байгаа орчны байдал хүний хариуцлагаас хамаардаг бол хувь хүний сайн сайхан амьдрал хүрээлэн байгаа орчноос хамаарна. Химийн хичээлээр хорт бодисуудын тухай заахдаа хүмүүсийн байгаль орчны бохирдлоос хамгаалуулах эрх, эрүүл аюулгүй орчинд аж төрөх эрх зэргийн тухай ойлголттой холбож зааж

болох, мөн физикийн хичээлээр цахилгаан энергийг гарган авах тухай заахдаа энергийн үүсгүүрүүдийг аль болох хүний бие махбодод хор багатай, орчны бохирдол багатай байлгах нь тэдний эрүүл аюулгүй орчинд аж төрөх эрх буюу нийгмийн эрхийг хангахтай холбож өгч болохыг бүлгүүд гаргаж ирж байлаа.

Ийнхүү тодорхой сэдвээр хүний эрхийг нэгтгэж заах тухай бүлгээр ажилласны эцэст ЕБС-ийн бүхий л хичээлүүдээр хүний эрхийн тухай ойлголтыг нэгтгэж заах маш өргөн боломж байгааг илүү сайн ойлгож мэдэрснээ сургалтанд оролцогч бүр дүгнэж байлаа.



«Ус» сэдвээр хүний эрхийг нэгтгэж заах нь. Байгалийн ухааны багш нарын баг. Улаанбаатар хот. 2007 оны 1 сар.

Хүний эрх биеийн тамирын хичээлээр:

Говьсүмбэр аймгийн биеийн тамирын багш нар “Маамын Лхагваагийн амьдрал” сэдвээр түүний Монгол улсын бөхийн спортод гаргасан амжилтыг сурагчдад таниулах замаар эрх нь хэрхэн зөрчигдөж байсныг ойлгуулах, үнэн зөв мэдээллийг таниулах зорилготойгоор хичээлийн төлөвлөлт хийсэн байлаа.

Хүний эрх иргэний боловсрол хичээлээр:

Сургалтанд оролцогчид Иргэний боловсрол хичээлийн төлөвлөгөөг багаар ажиллан гаргаж ирсэн нь 2006-2007, 2007-2008 оны хичээлийн жилд мөрдөх ЕБС-ийн Сургалтын төлөвлөгөөнд цоо шинээр тусгагдсан “Иргэний боловсрол” хичээлийн агуулга стандарт, арга зүй бүрэн боловсрогдоогүй байгаа энэ үед практик ач холбогдолтой боллоо. Завхан аймгийн бага боловсролын сургалтын менежерүүдийн баг Иргэний боловсролын хичээлийн агуулга, арга зүйг дараах байдлаар гаргаж ирсэн юм:

1-р бүлэг. Ахуй амьдралын үйл ажиллагааны аюулгүйн үндэс, арга ухаан
2-р бүлэг. Хүн байгаль дэлхийтэйгээ зөв харьцах ёс суртахуун

3-р бүлэг. Иргэний ардчилсан нийгэмд ажиллаж амьдрах чадвар эв дүй Хичээлийг явуулах арга зүй нь

- Мэтгэлцээн
- Аялал
- Өдөрлөг, үдэшлэг
- Уралдаан, тэмцээн
- Ярилцлага

• Танхимаар болон танхимын бус хэлбэрээр байна гэж гаргаж ирсэн нь тэдэнд практик ач холбогдолтой боллоо.



Завхан аймгийн бага боловсролын сургалтын менежерүүдийн баг. 2006 оны 8 сар.

Хүүхдийн эрх. Хүүхдийн эрхийн Конвенц, түүний хэрэгжилт.

Сургалтын нэг хэсэг Хүүхдийн эрхийн асуудал байлаа. Оролцогчид хүүхдийн эрхийн олон улсын баримт бичиг эх сурвалжуудтай танилцсаны дараа хүүхдийн эрхийн тухай болон Монгол дахь хүүхдийн эрхийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг Фото хэлэлцүүлгээр бүлгээр ажиллан гаргаж ирлээ. Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцэд “Хүүхдийн эрүүл мэндэд хор нөлөө учруулах, боловсрол олоход нь саад болохуйц ажил эрхлэх явдлаас хамгаалагдах эрхтэй” мөн МУ-ын Боловсролын Тухай Хуулийн 6-р зүйлд “МУ-ын иргэн нь ажил эрхлэхийн зэрэгцээ суралцах эрхтэй” гэж заасан хэдий ч бодит байдал дээр амьдралын эрхээр сургуулиас завсардан тэрэг түрэх, гудамжинд ширхэгийн наймаа эрхлэх, алт, нүүрс зэрэг уул уурхайд ажиллах, айлын мал хөлсөөр маллах зэргээр ямар нэг хэлбэрийн ажил эрхэлж байгаагаас олон хүүхэд суралцах, хөгжих, нийгмийн амьдралд оролцох, эсэн мэнд бойжих эрхээ эдэлж чадахгүй байна гэдгийг багууд бүлгээр ажиллан гаргаж ирэв.

Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн тухай

Өнөөдөр, Дэлхийн өнцөг булан бүрт олон мянган байгууллагууд хүний үндсэн эрхийн нэгэн хэсэг болох эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн асуудлаар ажиллаж байна. “Уламжлалт” хүний эрхийн байгууллагууд хүртэл эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн асуудлыг анхаарч дэлхийн өнцөг булан бүрт эдгээр эрхийг дэмжин, хамгаалахын төлөө ажиллаж байна. Манай сургалтын нэг хэсэг ч эдгээр эрхийн тухай ойлголтыг дээшлүүлэхэд чиглэгдэж байлаа.

Сургалтын энэ хэсэгт Эдийн засаг, нийгэм, соёлын тухайлсан эрхүүд болох:

- Хөдөлмөрлөх, аятай, таатай нөхцлөөр хангагдах эрх
- Нийгмийн халамж хамгаалал хүртэх эрх
- Хүрэлцээтэй хоол хүнс хэрэглэх эрх
- Хувцастай байх эрх
- Зохистой орон гэрээр хангагдах эрх
- Ундны цэвэр усаар хангагдах эрх
- Хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрх
- Сурч, боловсрох эрхүүдийн талаарх ойлголтыг өгсний дараа

Усны тухай “2070 онд бичсэн захидал” видео материалыг үзүүлэв.



Хүүхдийн эрхийн сургалтын хэсэг. Улаанбаатар хот.



Хүүхдийн эрхийн сургалтын хэсэг. Завхан аймаг. 2006 оны 8 сар.



Сургалтын дараах мөч. Орхон аймаг.

Сургалтыг юу гэж үнэлэв?

Сургалтанд оролцогсдоос өгсөн үнэлгээг нэгтгэж үзвэл:

Сургалт семинарын зорилго ямар түвшинд хангагдав? гэсэн асуултанд маш сайн гэж 91.2% нь хариулсан байлаа.

Сургалтын гарын авлага материал хир түвшинд хангагдав? гэсэн асуултанд маш сайн гэж 98.2% нь хариулсан байна.

Сургагч багшийн заах арга барил хир ойлгомжтой байв? гэсэн асуултанд маш сайн гэж 95.2% нь хариулсан байна.

Сургалт таны цаашдын ажилд хир тустай болов? гэсэн асуултанд маш тустай гэж 93.3% нь хариулсан байна.

Та сургалтанд оролцсоныхоо дараа ямар шинэ зүйлс, үйл ажиллагаа явуулахыг хүсч байна вэ гэсэн асуултанд сургуулийнхаа бусад багш нарт энэ чиглэлээрээ сургалт явуулах болно гэж 277 хүн хариулсан байхад Хүний эрхийн тухай ойлголтыг хичээлдээ нэгтгэж заана гэж 421 хүн хариулсан байв.

Сургалтын үр дүнг сайжруулахын тулд цаашид юу хийх нь зүйтэй гэж бодож байна вэ гэсэн асуултанд 491 хүн сургалтыг цааш нь бүх багш нарт хүргэх нь зүйтэй гэж хариулсан байна.



биднээс хүссэн юм.

Мөн Дорнод аймгийн БСГ-ын цахим хуудсанд "...Сургалтанд оролцсон багш нар хичээл бүхэн хүний эрхийн шударга ёсны зарчмуудтай холбогдож байвал бидний ирээдүй жинхэнэ хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлон байгуулах туйлын зорилгодоо хүрэх боломжтой юм байна гэсэн дүгнэлтэнд хүрч цаашид их зүйлийг хийх, өөр олон багшид энэ сургалтыг хүргэх нь зүйтэй гэсэн хүсэлтэй байгаагаа Эмнести Интернэшнл байгууллагын сургагч багш нарт хэлж байлаа..." гэж бичсэн байна.

Мөн сургалтыг зохион байгуулсан аймаг, нийслэлийн БСГ-аас ирүүлсэн албан тоотод бидний сургалтыг чухлаар үнэлж, Боловсролын Шинэчлэлийн тулгамдсан асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхэд чухал алхам болох энэхүү сургалтын үзэл санааг бусад багш нарт хүргэж ажиллахыг

<http://www.dornod.mn> хаягаар орж үзнэ үү.

Төслийн үзэл санааг олон хүнд хүргэх чиглэлээр хамтран ажиллах хүсэлтийг орон нутгийн боловсролын байгууллага, ҮЭ-ийн байгууллага, ЕБС, хамт олноос хүлээж аваад байна.

Монголын Багш нарын Гэгээрэл Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны хүсэлтээр манай сургагч багш нар ЕБС-дын үйлдвэрчний хороон дарга нарын дунд нэмэлт 1 удаагийн сургалтыг 34 хүнд явууллаа.

"Боловсролын Шинэчлэл-Иргэний Нийгмийн Байгууллагуудын Оролцоо" сэдэвт уулзалт ярилцлагад оролцогчид болон БСШУЯ-аас зохион байгуулсан "12 жилийн ЕБС-ийн сургалтын тогтолцоонд шилжих төлөвлөгөө" сэдэвт семинарт оролцогч мэргэжлийн судлаачид, бодлого боловсруулагчдад төслийн үзэл санаа, үр дүнг танилцуулан нийт 58 хүнд төслийн хүрээнд хэвлэгдсэн ном гарын авлагыг хүргэж ажиллалаа.

Мөн 2007 оны 4 сард БСШУЯ-аас зохион байгуулах сурах бичиг зохиогчдоод зориулсан сургалтанд сургагч багшаар ажиллах саналыг хүлээж аваад байна.



Сургалтанд оролцогчид сургагч багш нартаа талархаж байгаа нь.



Сургалтын дараа. 2006 оны 10-р сар. Дархан-Уул аймаг



Сургалтын дараа. 2006 оны 10-р сар. Дархан-Уул аймаг

Төслийн үр дүн

· Сургалтанд хамрагдсан нийт 763 оролцогчид хүний эрхийн боловсролын гарын авлага, материалаар хангагдлаа.

· Сургалтанд хамрагдагсад ХЭБ-ын талаархи мэдлэг чадвараа дээшлүүлж, тэдний эрхэд суурилсан боловсролын талаархи мэдлэг, чадварыг нь нэмэгдүүлснээр хүүхдийг хөгжилд хүргэх боловсролын таатай орчин бүрдүүлэхэд хувь нэмэр боллоо.

· Байгууллагын сургагч багш нарын чадавхи дээшилж, ЕБС-ийн багш нарт зориулсан ХЭБ-ын сургалтын хөтөлбөр боловсроглоо.

Манай төслийн хүрээнд хийгдсэн сургалтууд нь суралцагчдад хувь хүнийх нь хувьд болон нийгмийн эрэлт хэрэгцээнд нь тулгуурласан Чанартай боловсрол эзэмшүүлэхэд нэн тулгамдаад байгаа багш нарын арга зүйг дээшлүүлэхэд чиглэсэн бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн бүх хийчээлүүдийн хэрэглээний агуулга, цогц чадамжид суурилсан мэдээллийг хүний эрхийн суурь зарчмуудтай холбон авч үзсэнээр сурагчид бусдыг хүндэтгэж, хариуцлагаа мэдэр, өөрийн эрхээ хэрэгжүүлэх чадвартай болгоход оршиж байлаа. Энэ ч утгаараа манай төслийн хүрээнд хийгдсэн сургалтууд нь багшийг хөгжүүлэх, тэдний сэтгэлгээ

хандлагыг өөрчлөх, хүүхдэд эрхийн мэдрэмжийг хөгжүүлэх, хүний эрхэд тулгуурласан сургалтын таатай орчин бүрдүүлэхэд зохих хувь нэмэр боллоо гэж төслийн баг үнэлж байна.

Мөн түүнчлэн Боловсролын стандарт, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын талаар баримтлах бодлого, 12 жилийн ЕБС-ийн сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр боловсруулах, 12 жилийн сургалтанд хэрэглэх сурах бичгийн талаар хэлэлцэгдэж байгаа өнөө үед манай сургалтын үзэл санаа зохих хувь нэмрээ оруулаа гэж үзэж байна.

Монголын Эмнести Интернэшнлийн ҮЗ-ийн гишүүн, ХЭБ-ын зохицуулагч С.Ганчимэг.

ТАЛАРХАЛ

"Хүний эрхийн боловсрол" төслийг дэмжиж ажилласан Монгол-Австралийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны Хөтөлбөр, НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр, Нийслэлийн Боловсролын Газар болон орон нутгийн Боловсрол Соёлын Газрын ажилтнууд, сургалтанд оролцсон бүх хүмүүст гүн талархал илэрхийлье.

Монголын Эмнести Интернэшнл



Монголын Эмнести Интернэшнл

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,
Бага тойруу - 44, 10 тоот
Утас/факс: 976-11-324705
И-мэйл: aimcc@magicnet.mn
www.amnesty.mn